



**НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2021 оны 12 сарын 17 өдөр

Дугаар 1/42

Улаанбаатар хот

Дүүргийн Улаан загалмайн хороонд
санхүүжилт олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1.14 дэх заалт, 25 дугаар зүйлийн 25.1, 25.2 дахь хэсэг, Монголын Улаан загалмайн нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6.1 дэх заалтыг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Баянзүрх дүүргийн Улаан загалмайн хороонд дэмжлэг үзүүлэх зорилгоор сар бүр тогтмол санхүүжилт олгосугай.

2. Санхүүжилтийг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний зардлаас гаргахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга /Ч.Мэндсайхан/, Ерөнхий нягтлан бодогч /Г.Төрхүү/ нарт зөвшөөрсүгэй.

3. Баянзүрх дүүргийн Улаан загалмайн хорооны үйл ажиллагаа, санхүүгийн тайланг сар бүр дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албанд тайлагнаж ажиллахыг Улаан загалмайн хороон дарга /Д.Жазмаа/-д даалгасугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга /Ч.Мэндсайхан/-д үүрэг болгосугай.

ДАРГА



А.БАЯР